

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Энэхүү гэрээгээр харилцагч нь ЗэсКойны үйлчилгээг ашиглан сурталчилгааг түгээхэд ЗэсКойн зарцуулах, сурталчилгаа үзсэн хэрэглэгчийг зэскойноор урамшуулах, хэрэглэгчид ЗэсКойноо бирж дээр борлуулахтай холбогдон үүсэх талуудын хоорондын харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. ХАРИЛЦАГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

- 2.1 Койн зарахдаа заавал бирж дээр борлуулах
- 2.2 Койн шилжүүлэхдээ харилцагчаа сайн мэдсэн байх
- 2.3 Бүртгэлийг үүсгэхийн тулд фэйсбүүкээс хэрэглэгчийн нэр, зураг, овог, нэр зэрэг мэдээллийг ашиглаж байна. Хэрэглэгч өөрийн фэйсбүүкээс авсан мэдээллийг устгахыг хүсвэл info@seclab.mn мэйл хаяг руу хүсэлтээ илгээн устгах боломжтой.
- 2.4 Та өөрийн нууц үгийг алдалгүй, найдвартай хадгалах нь хэрэглэгчийн үүрэг байна.
- 2.5 Та өөрийн нууц үгээ өөрчлөх, шинэчлэх нь хэрэглэгчийн хариуцлага байна.
- 2.6 Та өөрийн нууц үгийг алдсанаас болон мэдээллийн нууцаа хадгалж чадаагүйгээс үүдэн гарсан асуудлын хариуцлагыг Үйлчилгээ үзүүлэгч хүлээхгүй.
- 2.7 Харилцагч нь хувийн мэдээллээ үнэн зөв өгөх үүрэгтэй бөгөөд өөрийн хувийн мэдээлэлд өөрчлөлт орвол ажлын 5 хоногт багтаан мэдэгдэнэ.
- 2.8 Харилцагч нь үйлчилгээг ашиглахтай холбоотой СекЛабаас өгсөн болон өөрөө үүсгэсэн ЗэсКойн дансны аюулгүй байдлыг хангах нэр, нууц үг, гүйлгээний пин кодыг хадгалж, хамгаалах үүрэгтэй.
- 2.9 Харилцагч өөрийн төхөөрөмж, гар утсан дээрх үйлчилгээ, аппликейшнүүдийг ашиглах, линк рүү орох, мэдээлэл, контент татаж авахдаа нууцлалын нөхцөлийг сайтар судлан танилцсан байх үүрэгтэй.
- 2.10 СекЛаб нь харилцагчийн хувийн мэдээллийн өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 15.5.1-т заасны дагуу Улсын бүртгэлийн эрх бүхий байгууллагаас гаргуулан авах эрхтэй байна.
- 2.11 СекЛаб нь энэхүү гэрээ болон хуульд заасны хуульд зааснаас бусад тохиолдолд харилцагчийн мэдээллийг бусдаар үл задруулна.

3.1 СекЛаб нь эрх бүхий төрийн байгууллагаас мэдэгдэл ирсэн тохиолдолд ЗэсКойн дансыг түр хаах эрхтэй.

3.2 СекЛаб нь дараах тохиолдолд харилцагчийн үйлчилгээг урьдчилан сануулалгүйгээр түр хаах, дансыг идэвхгүй төлөвт оруулах, данс хаах, гэрээг дуусгавар болгох эрхтэй. Үүнд, харилцагч:

3.2.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн

3.2.2 Үйлчилгээг хууль бус үйл ажиллагаанд ашигласан

3.2.3 Худал мэдээлэл өгсөн

3.2.4 Хууран мэхэлсэн

3.2.5 Мэдүүлсэн маягтаа оршин суудаггүй болох нь тогтоогдсон буюу хаягийн өөрчлөлтийн талаар ажлын 5 хоногийн дотор мэдэгдээгүй

3.2.6 СекЛабын үйл ажиллагаанд саад учруулсан

3.2.7 Өөрийн үйлчилгээг бусад харилцагчдад хортой, зүй зохисгүй байдлаар ашигласан

3.2.8 Харилцагчийн эрх зүйн чадамж дуусгавар болсон

3.2.9 Харилцагчийн ЗэсКойн данс үүсгэсэн гар утасны дугаар хураагдсан, ашиглалтаас гарсан, үүрэн холбооны үйлчилгээний гэрээ нь цуцлагдсан, дуусгавар болсон болон бусад адилтгах тохиолдлуудад дансыг идэвхгүй төлөвт шилжүүлнэ

3.2.10 ЗэсКойн дансаар сэжигтэй гүйлгээ хийгдсэн тохиолдолд

ДӨРӨВ. ХАРИУЦЛАГА

4.1 Талууд шууд бус хохирол нэхэмжлэхгүй.

4.2 Харилцагч болон гуравдагч этгээдийн үйлдэл эс үйлдэл, гэнэтийн болон давтагдашгүй хүчин зүйлээс учирсан хохирлыг СекЛаб хариуцахгүй.

4.3 Харилцагч гуравдагч этгээдэд санаатай болон санамсаргүй байдлаар гар утас, төхөөрөмжөө дамжуулсан, ашиглуулсан, хэрэглүүлсэн, аль нэг программыг буруу ажиллуулсан, гар утас, төхөөрөмж нь эвдэрсэн, унтарсан, сүлжээнээс гадуур гарсан, гар утасны эрх нь хаагдсан, 90 хоногтоо орсон эсхүл төхөөрөмж гар утас, сим картаа гэрээнд зааснаас бусад байдлаар ашигласнаас гүйлгээ амжилтгүй болох гэх мэт аливаа үр дагавар, хохирол зардлыг өөрөө бүрэн хариуцна.

4.4 СекЛаб нь гуравдагч этгээдийн мэдээлэл, контент, аппликейшн, үйлчилгээг татсан, хэрэглэснээс үүсэх хариуцлагыг хүлээхгүй болно. Харилцагч дээрх бүтээгдэхүүн,

үйлчилгээнд нэвтрэхдээ вирусийн болон хамгаалалтын арга хэмжээ авах үүрэгтэй.

ТАВ. ДАВТАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС

- 5.1 Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаанаар тухайлбал гал түймэр, үер, хур тунадастай болон шороон шуурга, газар хөдлөлт, аянга цахилгаан, галт уулын болон бусад тэсрэлт, дэлбэрэлт, цаг агаарын хэт халалт ба хүйтрэлт эсхүл төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээрийн дэглэм, гоц халдварт өвчин, ажил хаялт, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, үймээн самуун, зэвсэгт мөргөлдөөн, дайн (зарлагдсан болон зарлагдаагүй), террорист халдлага, улс орныг хамарсан түлш, эрчим хүчний хязгаарлалт, бүх нийтийг хамарсан түлш, эрчим хүчний хязгаарлалт, бүх нийтийг хамарсан сүлжээний сүлжээний хэт ачаалал, доголдол тасалдал зэрэг гэнэтийн буюу давагдашгүй шинжтэй нөхцөл байдлын улмаас талууд гэрээгээ хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээхгүй.
- 5.2 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлүүдийн улмаас үүдсэн нөхцөл байдал 30 хоногоос дээш хугацаагаар үргэлжилсэн тохиолдолд гэрээг цуцлагдсанд тооцно.

ЗУРГАА. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 6.1 Энэхүү гэрээтэй холбогдон гарч болзошгүй бүх санал зөрөлдөөн, маргааныг талуул харилцан зөвшилцөж замаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тийнхүү шийдвэрлэж чадахгүй